



“УБТЗ” ХНН-ИЙН УЛААНБААТАР  
ДАХЬ ВАГОН ДЕПОД

**МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ  
УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДҮГНЭЛТ**

14251 Улаанбаатар хот,  
Сүхбаатар дүүрэг, II хороо, Чингисийн өргөн чөлөө 11,  
Утас: 70112333, Факс: (976-11) 31-23-15  
E-mail: [info@mrt.gov.mn](mailto:info@mrt.gov.mn), <http://www.mrt.gov.mn>

2016.04.25 № 038/07/070/09

**Вагонд шалгалт хийсэн тухай**

“УБТЗ” ХНН-ээс 2016 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр ирүүлсэн хүсэлтийг дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан шинээр тоногдсон 482 дугаартай вагонд “УБТЗ” ХНН-ийн Зорчигч үйлчилгээний албаны Ерөнхий инженер Н.Отгонгэрэл, Улаанбаатар дахь Вагон депогийн Ерөнхий инженер О.Дэмбэрэлсүрэн, Засвар эрхэлсэн орлогч дарга Б.Бат-Эрдэнэ, Сүлжээний инженер-программист Г.Ганбат нарыг байлцуулан 2016 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр үзлэг шалгалт хийлээ.

Тус вагоны дотоод тоноглол, халаалт, усан хангамж, цахилгаан, явах ангиуд хэвийн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тасалгаа, унтлагын ор, ариун цэврийн өрөө, угаалтуур зэрэг нь захиалагчийн дагуу бүрэн хийгдсэн.

Тус вагон нь Тэргэнцэртэй зорчигчийг өргөх, буулгах төхөөрөмж ӨБТ-250 ашиглалтын зааврыг боловсруулан батлуулсан, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зориулалттай 482 дугаар вагоныг ашиглалтад оруулах комиссын актыг бүрдүүлсэн, ӨБТ-250 төхөөрөмжийн талаарх хөндлөнгийн дүгнэлтийг гаргуулсан ба хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг буулгаж, суулгах өргөх механизм, аюулгүй ажиллагааны хаалт, хамгаалалт, дохиолол, удирдлагын үйл ажиллагаа хэвийн, үйлчлэгч нар тусгай сургалт, зааварчилгад хамрагдсан байна.

**Дээрх байдлыг үндэслэн дүгнэх нь:**

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зориулалттай 482 дугаар вагон нь зорилтот зорчигчдын үйлчилгээний шаардлага болон техникийн аюулгүй ажиллагааг хангасан тул Төмөр замын тээвэрт ашиглах боломжтой байна.

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ХЯНАЛТЫН  
УЛСЫН БАЙЦААГЧ

М.ЭНХБОЛД

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ХЯНАЛТЫН  
УЛСЫН БАЙЦААГЧ

Б.ОЧХҮҮ